

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Огноо: 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдөр
Тендерийн дугаар: МРЦМ/202212196

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь өөрийн үйлдвэр, уурхайнуудын нөлөөллийн бүс дэх биологийн олон янз байдлын өнөөгийн төлөв байдал, мөн төслийн үйл ажиллагаанаас үүсч буй нөлөөллийг нарийвчлан тодорхойлох, дүйцүүлэн хамгаалал хийх газрын байршил сонгох, биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлээр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах чиглэлээр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Монголросцветмет” ТӨҮГ-ын “Бор-Өндөр” УБҮ-ийн үйл ажиллагаа явуулж буй Хэнтий аймгийн Бор-Өндөр, Дархан сум, Дорноговь аймгийн Өргөн, Айраг, Иххэт сум, Дундговь аймгийн Баянжаргалан сумдын нутагт хийлгэх үйлчилгээ болно.
3. Зөвлөх үйлчилгээ нь дараах багцуудаас бүрдэнэ. **Багцгүй**
4. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
 - Байгууллагын ерөнхий танилцуулга,
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар,
 - Тусгай зөвшөөрөл
 - Сүүлийн 3 жилийн аль нэгд уул уурхай, баяжуулах үйлдвэрийн дүйцүүлэн хамгаалал, биологийн олон янз байдлын судалгаа хийх зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагын мэдээлэл /гэрээ, гэрээ дүгнэсэн акт/,
 - Татварын өргүй тухай тодорхойлолт зэргийг ирүүлнэ.
5. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2022 оны 08 дугаар сарын 23–ны өдрийн 13 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 09 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ